

БАТЛАВ
“ДБЭХС” ТӨХКИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Г.ОТГОНБААТАР



2020.02.19

КАБЕЛЬ ТҮҮНИЙ ХОЛБОГЧУУД НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендерийн нэр: Кабель түүний холбогчууд

Тендерийн дугаар: ДБЭХС/202001089

Чойбалсан хот

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ДБЭХС” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “ Кабель түүний холбогчууд” нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020** оны **03** дугаар сарын **09** ны өдрийн **15** цаг **00** минутаас өмнө Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020** оны **03** дугаар сарын **09** ны өдрийн **15** цаг **10** минутанд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорнод аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр баг,
“Дорнод бүсийн эрчим хүчний систем”ТӨХК-ийн төв байр,
Утас: 88048877, 88091040
Факс: 70584545**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Сүүлийн /2019 он/ нэг жилийн санхүүгийн тайланг ирүүлнэ. 2019 оны борлуулалтын орлогын хэмжээ төсөвт өртөгөөс багагүй байх.</p> <p>2. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендер нээсэн өдрийн байдлаар татвар, хураамж, төлбөрийг шалгах бөгөөд аливаа төлбөрийн өртэй байх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>3. Улсын бүртгэлийн гэрчилгээ</p> <p>4. Үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу ирүүлэх</p> <p>5. Шүүхийн тодорхойлолт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>6. Бараа материалын олон улсын стандартын шаардлагыг хангасан тухай сертификат ирүүлнэ.</p> <p>7. Гэрээний үнээр, захиалгын хугацаанд техникийн шаардлага хангасан барааг хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг үнийн саналд хавсаргаж ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100Mb-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15Mb-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn –ээр банкны цахим системийг ашиглан төлнө</p> <p>Огноо: [2020 оны 03 дугаар сарын 09-ны өдөр] Цаг: [15 цаг 00 минут]</p>

ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: [ДБЭХС ТӨХК-ны Дорнод салбарын байр]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [2 давхар 203 тоот]</p> <p>Аймаг, хот: [Дорнод аймаг, Хэрлэн сум 6-р баг]</p> <p>Шуудангийн дугаар: [-]</p> <p>Улс: [Монгол Улс]</p> <p>Тендерийн нээлт хийх огноо: [2020 оны 03-р сарын 09-ны өдөр]</p> <p>Цаг: [15 цаг 10 минут]</p>
ТОӨЗ 2.3	<p>Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, баталгаажуулсан мэдэгдлийн хамт ирүүлнэ. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: /Багц байхгүй/</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

 БАТАВ СИСТЕМ СОЛУШН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ө.ЖАРГАЛСАЙХАН ДБЭХС ТӨХК-ИЙН 2020 ОНД ХУДАЛДАН АВАХ КАБЕЛЬ БА ТҮҮНИЙ ХОЛБООСУУДЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ					
2020.02.06					
№	Материалын нэрс	Техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Стандарт, шаардлага
1	Холболтын муфтын 35-70мм ² /10кВ/	<p>Тостой цаасан болон пластмассан тусгаарлагчтай, ган төмөр хамгаалалттай болон хамгаалалтгүй 10 кВ хүртэлх хүчдэлийн кабелийг холбох зориулалттай. Орчны температур -50С-с +50С, харьцангуй чийгшил 98% хүртэлх нөхцөлд 35С температурт ашиглана.</p>	ком	10	СТП10-35-70мм ² муфттай дүйцэх
2	Холболтын муфтын 150-240мм ² /10кВ/		ком	7	СТП10-150-240мм ² муфттай дүйцэх
3	Холболтын муфтын 70-120мм ² /10кВ/		ком	11	СТП10-70-120мм ² муфттай дүйцэх
4	Төгсгөлийн муфтын 35-50мм ² /10кВ/		ком	12	КнТП10-35-50 муфттай дүйцэх
5	Төгсгөлийн муфтын 70-120мм ² /10кВ/		ком	10	КнТП10-70-120 муфттай дүйцэх
6	Кабель 3*120 мм ² /10кВ/	<p>Хөнгөнцагаан дамжуулагчтай цахилгаан хүчиний кабель. Зууралттай тосон нэвчлэлтэй цаасан тусгаарлагчтай байх, гадна талдаа хуягтай байх, Хөнгөнцагаан дамжуулагчийн механик таталтын хүч нь 30 Н/мм²-ээс хэтрэхгүй, Хэвийн хүчдэл 10кВ(ажлын дээд хүчдэл 12кВ), давтамж 50Гц, Ажиллах температур -500-аас +500С, Агаарын чийглэг тэсвэрлэх чадвар (+35°С-аас ихгүй нөхцөлд) -98% хүртэл, Кабелийг урьдчилан халаахгүйгээр суурилуулалтын температур -25°С хүртэл, Дамжуулагчийг удаан хугацааны зөвшөөрөгдсөн температур +60°С</p>	Метр	150	ААБл-тай дүйцэх
7	Кабель 3*185 мм ² /10кВ/		Метр	30	ААБл-тай дүйцэх
8	Кабель 3*70 мм ² /10кВ/	<p>Кабелийг урьдчилан халаахгүйгээр суурилуулалтын температур -25°С хүртэл, Дамжуулагчийг удаан хугацааны зөвшөөрөгдсөн температур +60°С</p>	Метр	30	ААБл-тай дүйцэх
9	Кабель 3*95 мм ² /10кВ/		Метр	30	ААБл-тай дүйцэх

ХЯНАСАН:

ТХА-НЫ ДАРГА

ИА-НЫ ДАРГА

ЗТХ-ЫН ИНЖЕНЕР

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

ЦШС-НИЙ ЦЕХИЙН ДАРГА

Т.ТӨМӨРБААТАР

Б.БЯМБАА

Б.БАТ

Ж.БАЯР

- Баглаа, боодол:** Хайрцаг, баглаа боодол бүрэн бүтэн байх
- Бараа хүргэх газар:** ДБЭХС ТӨХК-ний төв агуулах
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Гэрээ байгуулагдсан өдрөөс 45 хоног

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэ	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	Холболтын муфть 35-70мм ² /10кВ/	ком	10	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
2	Холболтын муфть 150-240мм ² /10кВ/	ком	7	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
3	Холболтын муфть 70-120мм ² /10кВ/	ком	11	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
4	Төгсгөлийн муфть 35-50мм ² /10кВ/	ком	12	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
5	Төгсгөлийн муфть 70-120мм ² /10кВ/	ком	10	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
6	Кабель 3*120 мм ² /10кВ/	м	150	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
7	Кабель 3*185 мм ² /10кВ/	м	30	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
8	Кабель 3*70 мм ² /10кВ/	м	30	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	
9	Кабель 3*95 мм ² /10кВ/	м	30	ДБЭХС ТӨХК-ний агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс 30 хоног дотор	Гэрээ байгуулсан өдрөөс 45 хоног дотор	

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(ДБЭХС ТӨХК)-ын Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
<p>Гэрээний үнийн дүнгийн [100]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² | 9.1. Алданги оногдуулах хувь: [0,5]
Алдангийн нийт дүн: [10%] |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дунгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тооогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]